



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН
ГЕОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН СУРГУУЛЬ



№ 31, 2015

ГЕОЛОГИ



Улаанбаатар
2015 он

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ
СУРГУУЛЬ
ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН СУРГУУЛЬ



ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

ИВЭЭН ТЭТГЭГЧ

ГЕОЛОГИ

Геологийн Эрдэм Шинжилгээ, сургалт арга зүйн сэтгүүл
№ 31, 2015

МОНГОЛ ОРНЫ ГИДРОГЕОЛОГИ, ИНЖЕНЕР ГЕОЛОГИ,
ГЕОЭКОЛОГИЙН АСУУДЛУУД №23

Улаанбаатар хот
2015 он

Дундговь аймгийн төв болон баруун бүсийн конвекцийн үзэгдлийн судалгаа

Ц.Мөнхдэлгэр, С.Эрдэнэсүх, Л.Оюунжаргал

Хөв, цөөрөм байгуулах боломжийн судалгаа

Б.Мөнхтөр

Улаанбаатар хотын үерийн аюулын зураглал

М. Дамдинпүрэвням

ДУРСАМЖ, ТЭМДЭГЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ

Гурвалсан ажлын дөрвөн арван жил

Д.Чулуун, О.Гэрэл, Ж.Ган-Очир

Шинэ ном

Н.Батсүх, А.Ариунзаяа

Хэрлэнгийн олон улсын геологийн экспедицийн

XIX дугаар хурлын тухай товч мэлээлэл

Д.Сурмаажав, Д.Батжаргал

Хунт нуурын пентонит шаврын ордыг нээсэн тухайд

С.Пүрэвсүрэн

“Нийгэм эдийн засгийн хөгжилд байгалийн нөхцөл, нутаг дэвсгэрийн онцлогийг харгалзан үзэх нь” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын тухай

Н.Үржинбадам

Монголын гидрогеологчид (Теле кино зохиомж)

Н.Батсүх

Эрдэм шинжилгээний ээлжит хурлын тухай

ХӨВ, ЦӨӨРӨМ БАЙГУУЛАХ БОЛОМЖИЙН СУДАЛГАА

Б.Монхтөр

Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, Усны нөөц, ус ашиглалтын салбар

Хураангуй

Монгол орны хувьд усны хүрэлцээ харилцан адилгүй байдаг. Өндөр уулын болон говь, хээрийн бүсийн байгалийн ил задгай усгүй, газрын доорхи усны нөөцөөр хомс (худаг гаргах боломжгүй) бэлчээр нутгийг ашиглахад хаврын цасны шар ус, зуны аадар борооны үерийн усыг уст цэгийн нэгэн төрөл болох хөв, цөөрөм байгуулах замаар усыг хуримтлуулж усны нөөцийг нэмэгдүүлэх бүрэн боломжтой.

Малын усан хангамж, бага талбайд төмс хүнсний ногоо тариалахад энэ хөв, цөөрмийг ашиглах цаашлаад бяцхан байгуулмал баян бүрд бий болгоход ач тус их билээ.

Мөн жижиг гол горхи, тасарч ширгэдэг булаг шандын усыг хуримлуулах замаар хөв цөөрмийг байгуулдаг. Цасны усыг хуримтлуулж бороо орж гол горхины ус байгалийн аясаараа сэргэх хүртэл хуритлуулсан усаараа малаа услах боломжтой юм.

Мөн гадаадын зарим улсууд хотынхоо усан хангамжийг сайжруулах зорилгоор зарим гол дээрээ усны нөөцийг нэмэгдүүлж, урсацын тохируулгатай далан боомт барьдаг байна. Нэгэнт боомт барьж усны нөөцийг нэмэгдүүлснээр тухайн бүс нутгийн байгаль экологид эерэг нөлөөлөл үзүүлдэг. Одоогоор манай оронд энэ төрлийн үйл ажиллагаа хийгдээгүй байгаа бөгөөд санал, ТЭЗҮ зэрэг нь зохиогдсон байдаг.

ЦӨӨРӨМ гэдэг нь байнгын урсгал ус ба хур бороо цасны усны түрэлт болон урсацыг тохируулах, усыг хуримтлуулах зорилгоор энгийн ба инженерийн аргаар ухлаганд байгуулсан, эсвэл байгалийн тогтоцоор өөрөө үүсэж бий болсон 1 га хүртэл хэмжээний усан тогтоол усыг хэлнэ.

ХӨВ гэдэг нь хур борооны болон цасны хайлбар ус түр урсдаг хуурай сайр, гуу жалгыг, мөн тасарч ширгэдэг жижиг гол, горхины гольдролыг хааж барьсан шороон боомт, ус хуримтлуулах сан, ус гаргуур, илүүдэл ус хаюур зэргээс бүрдэх усны барилга байгууламжийг хэлнэ.

Түлхүүр үг: Хөв, цөөрөм, усан сан

Оршил

Урсацын хэмжээ нь багассан мөн бэлчээр сайтай боловч гадаргын усны сүлжээ муутай, газрын доорх усаар хангах боломж хязгаарлагдмал бүс нутагт бэлчээрийг усжуулах, мал аж ахуйг усаар тогтортой хангах зорилгоор тухайн орон нутгийн байгаль цаг уур, орчин нөхцөлд зохицсон инженерийн хийцтэй хиймэл нуур, хөв, цөөрмүүдийг шинээр бий болгож ашиглах нь орон нутаг болон иргэдэд ихээхэн ашиг тустай бүтээн байгуулалт юм.

Монгол орон нь газар зүйн байрлал, уур амьсгалын хатуу ширүүн нөхцөлд оршдог бөгөөд төв ба зүүн хойд Азийн өндөрлөг дээр орших 1564.1 мянган км² нутагтай, газар нутгийн 80 гаруй хувь нь далайн түвшнээс 1000м, түүнээс дээш оршино. Дэлхийд дунджаар 860 мм тундас унадаг байхад манайд дунджаар 250